



МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО
MONGOLIAN AMATEUR SWIMMING FEDERATION

Founded in 1991
Affiliated to FINA, 1996
Affiliated to AASF, 2000

2024 оны 12-р сарын 18-ны өдөр

№ 11

Улаанбаатар хот

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

МУССХ-ны “Оны тамирчин, баг, онцлох хүнийг шалгаруулах журам”-ыг батлах тухай

“Монголын усан спорт сонирхогчдын холбоо” төрийн бус байгууллага (“Холбоо” гэх)-ын Удирдах зөвлөлийн хурал нь Холбооны дүрмийн 7.6-т Холбооны гишүүн нь “Үр бүтээлтэй ажиллаж, спортын өндөр амжилт гаргасны төлөө материалын болон сэтгэл санаа, нэр хүндийн урамшуулал хүртэх эрхтэй” гэснийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Холбооны “Оны тамирчин, баг, онцлох хүнийг шалгаруулах журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралтаар баталсугай.
2. Журмыг Холбооны бүх гишүүдэд сурталчлан таниулж, хэрэгжүүлэн ажиллахыг ЕНБД М.Энхбаатар болон Удирдах зөвлөлийн дэргэдэх мэргэжлийн Зөвлөлүүдэд үүрэг болгосугай.
3. 2024 оны “Оны шилдгүүдийг шалгаруулах ёслолын ажиллагаа болон шалгаруулалтыг зохион байгуулах хороо”-ны даргаар Дэд Ерөнхийлөгч Х.Ганбаатарыг томилсугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Батсайхан

П.БАТСАЙХАН



МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБООНЫ ОНЫ ТАМИРЧИН, БАГ, ОНЦЛОХ ХҮНИЙГ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Монголын усан спорт сонирхогчдын холбооны (цаашид “Холбоо” гэх) үйл ажиллагааг идэвхжүүлэх, тамирчин, баг хамт олны гаргасан онцлох амжилтыг үнэлэн шагнах, усан спортын хөгжилд оруулсан хувь нэмрийг нь шударга, ил тодоор шалгаруулан тодруулах үндсэн зарчмыг тогтооход оршино.
- 1.2 Удирдах зөвлөл, зөвлөлүүд болон холбооны гишүүн клуб, байгууллагууд шаардлага хангасан нэр дэвшигчийг нэр дэвшүүлэх эрхтэй.
- 1.3 Удирдах зөвлөлийн хурлаар нэр дэвшигчдийг хэлэлцэж эцсийн байдлаар тодруулна.

Хоёр. НОМИНАЦИ

- 2.1 Оны шилдгүүдээр зөвхөн нэг хүн, багийг доорхи төрлүүдэд шалгаруулна.
 - 2.1.1 Оны шилдэг эмэгтэй тамирчин
 - 2.1.2 Оны шилдэг эрэгтэй тамирчин
 - 2.1.3 Оны шилдэг баг
 - 2.1.4 Оны онцлох хүн
- 2.2 Шаардлага хангасан нэр дэвшигч байхгүй гэж үзвэл тухайн жил, тухайн төрөлд шилдгийг тодруулахгүй байж болно.

Гурав. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА, ШАЛГУУР

- 3.1. Шилдэг тамирчин шалгаруулахад дараах шалгууруудыг үндэслэнэ:
 - 3.1.1. Холбооны болон олон улсын тэмцээн, уралдаанд эзэлсэн байр, хүртсэн медаль, шагнал.
 - 3.1.2 Тэмцээний онцгой амжилтууд (шинэ рекорд амжилт тогтоох, Олимп, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний шалгуур цагийн үзүүлэлтийг биелүүлсэн байдал гэх мэт).
 - 3.1.3 Сахилгын зөрчилгүй байх.
 - 3.1.4 Тэмцээн, уралдаан болон бусад үйл ажиллагааны үеэр үлгэр жишээ зан үйл харуулсан байдал.



- 3.1.5 Багийн зорилгод хувь нэмэр оруулсан байдал.
 - 3.1.6 Бусад тамирчдыг дэмжиж, хамтран ажилласан байдал.
 - 3.1.7 Нийгэмд болон усан спортын хөгжилд үзүүлсэн эерэг нөлөө.
 - 3.1.8. Хүүхэд залуучуудад урам зориг өгч, үлгэр дууриалал болсон байдал.
- 3.2. Шилдэг баг шалгаруулахад дараах шалгууруудыг үндэслэнэ:
- 3.2.1. Улсын болон олон улсын тэмцээн, уралдаанд гаргасан багийн амжилт.
 - 3.2.2. Байгууллага, клубын дотоод зохион байгуулалт, сахилга бат.
 - 3.2.3. Бусад багуудтай хамтран ажилласан байдал.
 - 3.2.4. Клуб, байгууллагын нэр хүндийг өсгөсөн байдал.
 - 3.2.5. Холбооны хөтөлбөрийг дэмжин оролцсон, хэрэгжүүлсэн байдал.
- 3.3 Оны онцлох хүнийг шалгаруулахад дараах шалгууруудыг үндэслэнэ.
- 3.3.1 Холбооны зорилго зорилтыг биелүүлэх болон үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад оруулсан хувь нэмэр.
 - 3.3.2 Бүтээлч санаачилга, шинэ санаа гаргасан байдал.
 - 3.3.3 Хамт олны эв нэгдлийг хангах болон ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэхэд оруулсан хувь нэмэр.
 - 3.3.4 Үүргээ цаг тухайд нь чанартай биелүүлсэн байдал.
 - 3.3.5 Холбооны үйл ажиллагааг сурталчлах, эерэг зөв мэдээллийг олон нийтэд хүргэсэн байдал.
 - 3.3.6. Сургалтад хамрагдаж, өөрийгөө хөгжүүлсэн байдал болон ур чадвараа сайжруулсан байдал
 - 3.3.7 Зохион байгуулалт, манлайлал, үлгэр дуурайлал үзүүлсэн байдал.
 - 3.3.8 Хамт олноос авсан үнэлгээ, санал

Дөрөв. ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО БОЛОН ШАЛГАРУУЛАЛТ

- 4.1 Оны шилдгүүдийг шалгаруулах ёслолын ажиллагаа болон шалгаруулалтыг зохион байгуулах хороог (цаашид “Хороо” гэх) Ерөнхийлөгчийн томилсон Дэд Ерөнхийлөгчөөр даргалуулж, Ерөнхий нарийн бичгийн дарга болон УЗ-ийн дэргэдэх зөвлөлүүдийн бүрэлдэхүүнээс тус бүр нэг төлөөлөлтэйгөөр бүрдүүлнэ.
- 4.2 Шалгаруулалтад оролцох тамирчин, байгууллага клубын материалыг дараах байдлаар бүрдүүлнэ:
- 4.2.1. Тэмцээн, уралдаанд оролцсон тайлан, нотлох баримтууд.
 - 4.2.2. Ёс зүй, сахилга баттай холбоотой үнэлгээ.
 - 4.2.3. Байгууллага, клубын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааны талаархи мэдээлэл.
 - 4.2.4. Холбооны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн талаархи тоон мэдээлэл, бүртгэл
- 4.3. Хорооны гишүүд бүх материалыг судалж, шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлгээ өгч шалгаруулалтыг явуулна.



4.4. Хорооны шалгаруулсан нэр дэвшигчийг Холбооны Ерөнхийлөгч батламжилж эцсийн байдлаар оны шилдгийг тодруулна.

4.5. Хороо нь Шилдэг тамирчныг олон нийтэд зарлах үйл ажиллагаа буюу шагнал гардуулах ёслолыг хариуцан зохион байгуулна.

4.6. Шалгаруулалтад Холбооны гишүүн клуб, байгууллагын гишүүн, идэвхтэй бэлтгэл сургуулилт хийж, тэмцээн уралдаанд оролцож буй тамирчин болон идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа гишүүн байгууллага, клуб болон Холбооны идэвхтэн оролцоно.

Тав. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ БОЛОН БУСАД

5.1. Шалгаруулалт нь жил бүр зохион байгуулагдана.

5.2. Энэхүү журамд заасан шалгуурыг хангасан нэр дэвшигч байхгүй гэж үзвэл хороо нь тухайн номинацийн шилдгийг тодруулахгүй байж болно.

5.3. Журмыг Холбооны Удирдах зөвлөл баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

5.4. Шилдэг баг, тамирчин, онцлох хүн шагналд дараах урамшуулал олгоно:

- Өргөмжлөл, цом.
- Мөнгө эсвэл эд материалын шагнал.

